



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН 2022 ОНЫ НЭГТГЭСЭН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/14/НА-СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: Ч.Болд  
Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn  
Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ  
Утас: 261628 Цахим хаяг: Bat-Erdenes@audit.gov.mn  
Аудитор: П.Ариунзаяа  
Утас: 261628 Цахим хаяг: Ariunzayap@audit.gov.mn

Улаанбаатар хот  
2023 он



**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	15
3.5.3 Нэмэлт төсөв .....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.5.1 Завсрын аудитын талаар .....	19
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20
5.1 Нийгмийн халамжийн дэд сангууд.....	20
5.2 Нийгмийн халамжийн төв сан .....	20
5.2.1 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21



**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АДЗ	Амьжиргаа дэмжих зөвлөл
НХС	Нийгмийн халамжийн сан
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан





# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Т.БАДРАХБАЯР ТАНАА

2023.03.24 № 01/663

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн халамжийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцолсон хэсэг

Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагаа нь Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл хөнгөлөлт олгох тухай, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль болон салбарын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актуудаар зохицуулагдаж, нийгмийн халамжийн 10 төрлийн 72 зүйлийн үйлчилгээг үзүүлж, үүнээс 66 үйлчилгээг /ehalamj.mn/ цахим системд нэвтрүүлсэн байна.


## Аудитын гол асуудал

Ирээдүйн өв сангийн тухай хуульд 2021 онд нэмэлт өөрчлөлт орж, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2022 оны төсвийн жилд Ирээдүйн өв сангийн эх үүсвэрээс олгох шийдвэр гарсан байна.

## Бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 5 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 97.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Z:\Yawsan\_Btchigi\2023\0315 SNAG-122.Docx





### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>16,419,395,179.64</b>	<b>26,930,200.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>1,280,534,950.05</b>	-
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>1,280,534,950.05</b>	-
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>1,280,534,950.05</b>	-
31213	Арилжааны банк дахь харилцах	1,280,534,950.05	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>15,138,860,229.59</b>	<b>26,930,200.00</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	73,230,229.59	7,603,200.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	15,065,630,000.00	19,327,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>16,419,395,179.64</b>	<b>26,930,200.00</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>15,379,742,092.00</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>15,379,742,092.00</b>	-
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>15,379,742,092.00</b>	-
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>15,379,742,092.00</b>	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	15,379,742,092.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,039,653,087.64</b>	<b>26,930,200.00</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,039,653,087.64</b>	<b>26,930,200.00</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,039,653,087.64</b>	<b>26,930,200.00</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	995,595,342.70	1,102,204,725.05
51220	Тайлант үеийн үр дүн	44,057,744.94	(1,075,274,525.05)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>16,419,395,179.64</b>	<b>26,930,200.00</b>



**2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,990,228,337,708.97</b>	<b>546,821,779,606.31</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>120,867,288,315.97</b>	<b>15,336,163,130.31</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>120,867,288,315.97</b>	<b>15,336,163,130.31</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>120,867,288,315.97</b>	<b>15,336,163,130.31</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,931,832,308.97	15,336,163,130.31
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	118,935,456,007.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,869,361,049,393.00</b>	<b>531,485,616,476.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,869,361,049,393.00</b>	<b>528,284,801,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,869,361,049,393.00	528,284,801,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>3,200,814,976.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	104,240,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,096,574,976.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,990,184,279,964.03</b>	<b>547,897,054,131.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,990,184,279,964.03</b>	<b>547,897,054,131.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,416,177,362.29</b>	<b>1,125,923,799.51</b>
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>16,759,810.00</b>	<b>49,816,782.00</b>
210702	Дотоод албан томилолт	16,759,810.00	49,816,782.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,359,356,043.29</b>	<b>1,045,598,567.51</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,127,279,164.44	917,198,117.51
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	74,546,778.85	9,112,150.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	157,530,100.00	119,288,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>40,061,509.00</b>	<b>30,508,450.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,061,509.00	30,508,450.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,988,768,102,601.74</b>	<b>546,771,130,331.85</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,984,427,565,293.70</b>	<b>514,982,843,040.21</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,972,970,065,293.70	514,982,843,040.21



**Нийгмийн халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,011,457,500,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,340,537,308.04</b>	<b>31,788,287,291.64</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,265,275,221.52	17,224,388,666.92
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,591,500.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	75,262,086.52	14,560,307,124.72
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>44,057,744.94</b>	<b>(1,075,274,525.05)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>44,057,744.94</b>	<b>(1,075,274,525.05)</b>



**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,990,228,337,708.97</b>	<b>546,821,779,606.31</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>120,867,288,315.97</b>	<b>15,336,163,130.31</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>120,867,288,315.97</b>	<b>15,336,163,130.31</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>120,867,288,315.97</b>	<b>15,336,163,130.31</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,931,832,308.97	15,336,163,130.31
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	118,935,456,007.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,869,361,049,393.00</b>	<b>531,485,616,476.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,869,361,049,393.00</b>	<b>528,284,801,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,869,361,049,393.00	528,284,801,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>3,200,814,976.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	104,240,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,096,574,976.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,990,664,381,667.90</b>	<b>548,102,314,556.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,990,664,381,667.90</b>	<b>548,102,314,556.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,462,889,133.75</b>	<b>1,126,821,660.51</b>
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>16,759,810.00</b>	<b>49,816,782.00</b>
210702	Дотоод албан томилолт	16,759,810.00	49,816,782.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,406,067,814.75</b>	<b>1,046,496,428.51</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,173,990,935.90	918,095,978.51
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	74,546,778.85	9,112,150.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	157,530,100.00	119,288,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>40,061,509.00</b>	<b>30,508,450.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,061,509.00	30,508,450.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,989,201,492,534.15</b>	<b>546,975,492,895.85</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,969,795,325,226.11</b>	<b>515,167,878,604.21</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,971,896,375,226.11	515,167,878,604.21



**Нийгмийн халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	997,898,950,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>19,406,167,308.04</b>	<b>31,807,614,291.64</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,330,905,221.52	17,224,582,666.92
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	22,724,500.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	75,262,086.52	14,560,307,124.72
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>(436,043,958.93)</b>	<b>(1,280,534,950.05)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(436,043,958.93)</b>	<b>(1,280,534,950.05)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,716,578,908.98	1,280,534,950.05
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,280,534,950.05	-



**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

*/төгрөгөөр/*

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>374,152,582.18</b>	<b>374,152,582.18</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	621,442,760.52	621,442,760.52
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	995,595,342.70	995,595,342.70
Тайлант үеийн үр дүн	-	-	44,057,744.94	44,057,744.94
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>1,039,653,087.64</b>	<b>1,039,653,087.64</b>
<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>1,039,653,087.64</b>	<b>1,039,653,087.64</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	62,551,637.41	62,551,637.41
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	<b>1,102,204,725.05</b>	<b>1,102,204,725.05</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,075,274,525.05)	(1,075,274,525.05)
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>26,930,200.00</b>	<b>26,930,200.00</b>



**2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	528,284,801,500.00	511,613,709,788.72	16,671,091,711.28	96.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	528,284,801,500.00	511,613,709,788.72	16,671,091,711.28	96.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,017,080,700.00	1,126,821,660.51	890,259,039.49	55.9
2107	Томилолт, зочны зардал	70,839,100.00	49,816,782.00	21,022,318.00	70.3
210702	Дотоод албан томилолт	70,839,100.00	49,816,782.00	21,022,318.00	70.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,757,844,600.00	1,046,496,428.51	711,348,171.49	59.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,319,799,600.00	918,095,978.51	401,703,621.49	69.6
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200,000,000.00	9,112,150.00	190,887,850.00	4.6
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	238,045,000.00	119,288,300.00	118,756,700.00	50.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	188,397,000.00	30,508,450.00	157,888,550.00	16.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	188,397,000.00	30,508,450.00	157,888,550.00	16.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	526,267,720,800.00	510,486,888,128.21	15,780,832,671.79	97.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	526,267,720,800.00	510,486,888,128.21	15,780,832,671.79	97.0
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	526,267,720,800.00	510,486,888,128.21	15,780,832,671.79	97.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	528,284,801,500.00	511,327,481,963.39	16,957,319,536.61	96.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	528,284,801,500.00	511,060,412,833.08	17,224,388,666.92	96.7
310001	Улсын төсвөөс санхүүжих	528,284,801,500.00	511,060,412,833.08	17,224,388,666.92	96.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	267,069,130.31	(267,069,130.31)	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	267,069,130.31	(267,069,130.31)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,280,534,950.05		



**2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>3,200,814,976.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>3,200,814,976.00</b>
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>3,200,814,976.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>3,178,090,476.00</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		3,178,090,476.00
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>22,724,500.00</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		22,724,500.00
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>3,200,814,976.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>3,200,814,976.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		104,240,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,096,574,976.00



### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааны зорилго нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламж үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй, чанартай хүргэхэд оршино. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг олгох ажлыг зохион байгуулах;
- Төрд байгаа иргэний мэдээллийг иргэнээс шаардахгүйгээр нийгмийн халамжийн үйлчилгээ, арга хэмжээнд хамруулах, түргэн шуурхай хүргэх, халамжийн нэгдсэн систем /ehalamj.mn/ цахим системийг нэвтрүүлж, үйлчилгээний менежментийг сайжруулах;
- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж, үйлчилгээтэй холбоотой иргэний өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь хууль журмын дагуу шийдвэрлэж ажиллах.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого, чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Нийгмийн халамжийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай” 167 дугаар тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоол;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

ХХҮЕГ-ын Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газар нь 2022 онд нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагаатай холбоотой дараах хяналт, шалгалтыг хийхээр төлөвлөж, гүйцэтгэсэн байна. Үүнд:

- *Төлөвлөгөөт хяналт, шалгалт:* Багануур, Баянгол, Сүхбаатар дүүргийн ХХҮХ, Дорноговь, Сүхбаатар, Орхон, Өмнөговь, Увс аймгийн ХХҮГ-ын Нийгмийн халамжийн сангийн зарцуулалтад;
- *Төлөвлөгөөт бус болон эрсдэлд суурилсан хяналт, шалгалт:* Ehalamj.mn программд Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж орсонтой холбоотой гарч болох эрсдэлийн үнэлгээг Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газар болон Мэдээлэл технологийн төвтэй хамтран хяналт шалгалт хийж зөвлөмж өгсөн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авч, тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй учир дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн халамжийн сангийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил, гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ХХҮЕГ-ын даргын 2018 оны А/174 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж, дээрх баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлог тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

НХС-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,392.5 сая төгрөгөөр буюу 99.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
			/мянган төгрөгөөр/ 3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,280,535.0	-	(1,280,535.0)
Авлага	15,138,860.2	26,930.2	(15,111,930.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>16,419,395.2</b>	<b>26,930.2</b>	<b>(16,392,465.0)</b>
Өр төлбөр	15,379,742.1	-	(15,379,742.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,039,653.1	26,930.2	(1,012,722.9)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>16,419,395.2</b>	<b>26,930.2</b>	<b>(16,392,465.0)</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Авлага дансны үлдэгдэл 26.9 сая төгрөг болж, өмнөх оноос 15,111.9 сая төгрөгөөр буурсан нь татаас санхүүжилтийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэлд нэр данс зөрүүтэй буцсан гүйлгээний 19.1 сая, Сонгинохайрхан, Багахангай дүүргийн ХХҮХ-ийн ХЭДС-д тушаах данс андуурсан гүйлгээний 0.2 сая, нийт 19.3 сая төгрөгийг Сангийн яамнаас авах татаас, санхүүжилтийн авлагаар, Налайх ХХҮХ-ээс иргэдэд илүү олгосон 7.6 сая төгрөгийг хувь хүнээс авах авлагаар бүртгэсэн байна.

Халамжийн тэтгэврийн 2021 онд олгогдоогүй 5.3 сая, халамжийн тэтгэмжийн 18.6 сая, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн 32.1 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж хөнгөлөлтийн 85.8 сая, амьжиргаа дэмжих зөвлөлийн урамшууллын 1.0 сая, хүүхдийн мөнгөний 1,506.8 сая, Монгол Улсын иргэн бүрд олгох 300.0 мянган төгрөгийн тэтгэмжийн 13,558.5 сая, ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн 171.6 сая төгрөгийг нөхөн олгосноос өр төлбөр дансны 15,379.7 сая төгрөгийн үлдэгдлийг бүрэн барагдуулсан байна.



### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

НХС-ийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 846,261.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа, ажил, үйлчилгээний зардлыг 2,934.8 сая, халамжийн зардлыг 360,341.8 сая төгрөгөөр бууруулж, 482,984.8 сая төгрөгөөр баталсан нь хүүхдийн мөнгөн тэтгэмжийг Ирээдүйн өв сангаас олгох болсонтой холбоотой байна. Тайлант онд НХС-ийн батлагдсан төсвийг Сангийн сайдын “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 239 дүгээр тушаалаар 45,300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр нийт төсвийг 528,284.8 сая төгрөгөөр тодотгосон байна.

Энэ нь Засгийн 2020 оны 167 тогтоолоор (Засгийн газрын 2020 оны 126, 248, 2021 оны 236, 2022 оны 60 дугаар тогтоолоор хугацааг сунгасан) нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 528,284.8 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр баталсан бөгөөд гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 511,613.7 сая төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь бараа, үйлчилгээний зардлын төсвийг 890.3 сая, нийгмийн халамжийн зардлыг 15,780.8 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71902	Нийгмийн халамж	528,284,801.5	511,613,709.9	16,671,091.6	96.8
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	697,281.1	208,725.7	488,555.4	29.9
1.2	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	466,191.0	203,148.30	263,042.7	43.6
1.3	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	853,608.6	714,947.70	138,660.9	83.8
1.4	80701	Халамжийн тэтгэвэр	189,700,000.0	182,936,029.30	6,763,970.7	96.4
1.5	80702	Жирэмсэн болон хөхүүл эхийн тэтгэмж	11,332,500.0	10,792,489.60	540,010.4	95.2



**Нийгмийн халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1.6	80705	Алдарт эхийн одонтой эхчүүдэд	31,313,800.0	31,009,200.00	304,600.0	99.0
1.7	80707	Асаргааны тэтгэмж	59,433,793.4	59,396,141.80	37,651.6	99.9
1.8	80709	Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж	46,356,197.3	46,034,915.20	321,282.1	99.3
1.9	80710	Асрамжийн үйлчилгээ	483,120.5	483,120.50	-	100.0
1.10	80711	Хоол тэжээлийн тусламж, дэмжлэг	23,275,488.0	19,957,713.20	3,317,774.8	85.7
1.11	80713	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламж	10,646,786.2	10,150,233.20	496,553.0	95.3
1.12	80714	Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт, тусламж	27,535,035.4	26,670,555.20	864,480.2	96.9
1.13	80718	Насны хишиг	25,449,000.0	25,062,840.00	386,160.0	98.5
1.14	80723	Цалинтай ээж	100,742,000.0	97,993,650.21	2,748,349.8	97.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд харьяа байгууллагын орон нутгийн төсвийн санхүүжилтээс 3,096.6 сая, Нэгдсэн Үндэсний Байгууллагын хүн амын хөгжлийн санхүүжилтээс 104.2 сая, нийт 3,200.8 төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс онцгой тохиолдлын болон олон нийтийн халамжийн үйлчилгээний зардалд 3,178.1 сая төгрөг зарцуулж, үлдэгдэл 22.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.



#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, аудитор П.Ариунзаяа нар гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер Ч.Болд, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн халамжийн сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 01/245 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 547,897.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5,479.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/54 дүгээр тушаалаар зохион байгуулсан хэлэлцүүлэгт 14.2 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж сургалт, семинар, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

##### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг



тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 1,641.6 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 161.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 1,479.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд "Нийгмийн халамжийн дэвтэр, маягт, ном, гарын авлага, тараах материал хэвлүүлэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах" нээлттэй тендер шалгаруулах журмаар тусгасан боловч худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүйгээр ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/230 дугаар тушаалаар харьяа аймаг, дүүргийн ХХҮГ, хэлтсүүдэд 1.0-8.0 сая төгрөгийг, нийт 125.0 сая төгрөгийн зардлыг шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 "Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө", 8 дугаар зүйлийн 8.4 "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах, хэвлэлийн зардлыг хэмнэх талаар албан шаардлага хүргүүлэв.

2. "Ахмад настанд амралт, сувиллын үйлчилгээ үзүүлэх байгууллага сонгон шалгаруулах" тендерийг ахмад настан гэрээ байгуулсан амралт, сувиллын газраас өөрөө сонгон үйлчлүүлдэг учир ахмад настны тоо, мөнгөн дүнг гэрээнд тусгах боломжгүй гэх шалтгаанаар худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 255 дугаар "Журам батлах тухай" тушаалын хавсралтаар батлагдсан "Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1 "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг энэ журмын дагуу зохион байгуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулах, ил тод нээлттэй болгох албан шаардлага хүргүүлэв.

3. ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/43 дугаар тушаалаар ахмад настанд амралтын үйлчилгээ үзүүлэх 26, сувиллын үйлчилгээ үзүүлэх 32 газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, гүйцэтгэлээр ахмад настны амралт, сувиллын үйлчилгээний зардалд 7,348.3 сая төгрөгийг шилжүүлсэн боловч жилийн эцэст гэрээг дүгнээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5." ... ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 "гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг", Хамтрах ажиллах гэрээний 2 дугаар зүйлийн 2.20 "Тухайн жилийн гэрээний хэрэгжилтийн тайланг энэхүү гэрээний хавсралтын дагуу гарган 2022 оны 12 дугаар сарын 15-ны дотор агентлагт бичгээр хүргүүлэн гэрээг дүгнүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Хамтран ажиллах гэрээнд заасан хугацаанд гэрээг дүгнэж байх, дотоод хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

НХС-ийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийх завсрын аудитын хугацаанд, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэлийг тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 731.1 сая төгрөгийн 4 албан шаардлага, 165.7 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлж ажилласан байна. Өмнөх оны зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	
Албан шаардлага	4	724,381.1	4	724,381.1	100.0
Зөвлөмж	1	165,695.7	1	165,695.7	100.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>890,076.8</b>	<b>5</b>	<b>890,076.8</b>	<b>100.0</b>

/Мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээг E-Halamj.mn системээр дамжуулан цахим хэлбэрт шилжүүлж, 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн арилжааны банк дахь харилцах дансыг ашиглахгүй болсон байна.

ХХҮЕГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 04/186 дугаар албан бичгээр харьяа газар, хэлтсийн нийгмийн халамжийн чиглэлээр ашиглаж байгаа арилжааны банк дахь харилцах дансыг хаах чиглэлийг хүргүүлсэн боловч хэрэгжилтэд хяналт тавьж нэгтгээгүй байгаа тул дараагийн аудитаар дахин авч үзэхээр шийдвэрлэв.



## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 49,289.2 сая төгрөгийн 8 алдаа илэрснээс аудитын явцад алдааг бүрэн залруулсан.

Аудитаар нийт 89.6 сая төгрөгийн 13 зөрчил илэрснээс, 40.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 49.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 10 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 89.6 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 5,479.0 сая төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

### 5.1 Нийгмийн халамжийн дэд сангууд

Нийгмийн халамжийн сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 30 дэд сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд 23 дэд сангийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 7 дэд сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна. Үүнээс 22 дэд сангийн санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, Налайх дүүргийн ХХҮХ-ийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Нийгмийн халамжийн дэд сангуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,056.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,989.2 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 25.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 албан шаардлага, 41.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 9 зөвлөмж хүргүүлсэн байна.

### 5.2 Нийгмийн халамжийн төв сан

Нийгмийн халамжийн төв сангийн аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 45,300.0 сая төгрөгийн 2 алдааг санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд:

- Тайлант онд нэмэлт санхүүжилтийн тайлан гаргаагүй;
- Улсын төсвийн санхүүжилтийн 45,300.0 сая төгрөгийн орлогыг данс буруу ангилж тайлагнасан.

Нийгмийн халамжийн төв сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 7.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 зөвлөмж өгсөн.

#### 5.2.1 Зөвлөмж

##### 1. Дансны авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх оноос шилжин ирсэн хувь хүмүүсээс авах 7.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагыг барагдуулах, дахин авлага үүсгэхгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/Мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Нийгмийн халамжийн төв сан</b>													
1	Нийгмийн халамжийн төв сан	2	45,300,000.0	1	-	1	45,300,000.0	2	45,300,000.0				
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>45,300,000.0</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>45,300,000.0</b>	<b>2</b>	<b>45,300,000.0</b>				
<b>Нийгмийн халамжийн дэд сан</b>													
1	Дорноговь аймгийн ХХУГ	1	-	1	-			1	-				
2	Хан-Уул дүүргийн ХХУХ	2	3,985,562.7	1	3,985,532.7	1	30.0	2	3,985,562.7				
3	Багануур дүүргийн ХХУХ	1	55.0	1	55.0			1	55.0				
4	Баянзүрх дүүргийн ХХУХ	1	3,450.1			1	3,450.1	1	3,450.1				
5	Сонгинохайрхан дүүргийн ХХУХ	1	139.0	1	139.0			1	139.0				
	<b>Дүн</b>	<b>6</b>	<b>3,989,206.8</b>	<b>4</b>	<b>3,985,726.7</b>	<b>2</b>	<b>3,480.1</b>	<b>6</b>	<b>3,989,206.8</b>				
	<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>49,289,206.8</b>	<b>5</b>	<b>3,985,726.7</b>	<b>3</b>	<b>45,303,480.1</b>	<b>8</b>	<b>49,289,206.8</b>				



Нийгмийн халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Нийгмийн халамжийн төв сан</b>													
1	Нийгмийн халамжийн төв сан	1	7,603.2					1	7,603.2				
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>7,603.2</b>					<b>1</b>	<b>7,603.2</b>				
<b>Нийгмийн халамжийн дэд сан</b>													
1	Говь-Алтай аймгийн ХХҮГ	1	-					1	-				
2	Сэлэнгэ аймгийн ХХҮГ	2	-					2	-				
3	Ховд аймгийн ХХҮГ	1	4,200.0					1	4,200.0				
4	Хан-Уул дүүргийн ХХҮХ	2	5,392.0			1	3,347.0	1	2,045.0				
5	Багануур дүүргийн ХХҮХ	1	8,000.0					1	8,000.0				
6	Баянзурх дүүргийн ХХҮХ	1	2,184.6					1	2,184.6				
7	Налайх дүүргийн ХХҮХ	2	47,983.5			1	22,483.5	1	25,500.0				
8	Баянгол дүүргийн ХХҮХ	1	-					1	-				
	<b>Дүн</b>	<b>11</b>	<b>67,760.1</b>			<b>2</b>	<b>25,830.5</b>	<b>9</b>	<b>41,929.6</b>				
	<b>Нийт дүн</b>	<b>12</b>	<b>75,363.3</b>			<b>2</b>	<b>25,830.5</b>	<b>10</b>	<b>49,532.8</b>				



Нийгмийн халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
				Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
1	Архангай аймгийн ХХҮГ	1	-					1	-
2	Дорноговь аймгийн ХХҮГ	1	-			1			
3	Дорнод аймгийн ХХҮГ	1	6,000.0					1	6,000.0
4	Хан-Уул дүүргийн ХХҮХ	1	111,428.0			1	111,428.0		
5	Баянзүрх дүүргийн ХХҮХ	1	129,593.1					1	129,593.1
6	Баянгол дүүргийн ХХҮХ	1	984,600.0					1	984,600.0
7	Сүхбаатар дүүргийн ХХҮХ	1	192,123.0					1	192,123.0
8	Чингэлтэй дүүргийн ХХҮХ	1	13,470.0					1	13,470.0
9	Багахангай дүүргийн ХХҮХ	1	50,411.9			1	50,411.9		
10	Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ	1	153,987.1					1	153,987.1
	<b>Дүн</b>	<b>10</b>	<b>1,641,613.1</b>			<b>3</b>	<b>161,839.9</b>	<b>7</b>	<b>1,479,773.2</b>
<b>Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
1	Нийгмийн халамжийн төв сан	4	7,487,500.3			4	7,487,500.3		
2	Говь-Алтай аймгийн ХХҮГ	1	32,544.0			1	32,544.0		
3	Говьсүмбэр аймгийн ХХҮГ	1	8,000.0			1	8,000.0		
	<b>Дүн</b>	<b>6</b>	<b>7,528,044.3</b>			<b>6</b>	<b>7,528,044.3</b>		
	<b>Нийт дүн</b>	<b>16</b>	<b>9,169,657.4</b>			<b>9</b>	<b>7,689,884.2</b>	<b>7</b>	<b>1,479,773.2</b>





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ 711/АДИ/1123

Улаанбаатар хот

СНАГ-2023/14/114-СТА-317С

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/54 дүгээр тушаалаар зохион байгуулсан хэлэлцүүлэгт 14,245,250.0 /арван дөрвөн сая хоёр зуун дөчин таван мянга хоёр зуун тавин/ төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 388 дугаар тогтоолын 5.3 "бүх төрлийн сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж сургалт, семинар, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бадрахбаяр, Халамжийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Билэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Ч.БОЛД  
П.АРИУНЗАЯА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ 720/А017/1123

Улаанбаатар хот

СНАГ-2023/14/НА-ОАА-317С

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд "Нийгмийн халамжийн дэвтэр, маягт, ном, гарын авлага, тараах материал хэвлүүлэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах" нээлттэй тендер шалгаруулах журмаар тусгасан боловч худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүйгээр ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/230 дугаар тушаалаар харьяа аймаг, дүүргийн ХХҮГ, хэлтсүүдэд 1,000,000.0-8,000,000.0, нийт 125,000,000.0 /нэг зуун хорин таван сая/ төгрөгийн зардлыг шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т "Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө", 8 дугаар зүйлийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах, хэвлэлийн зардлыг хэмнэх, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бадрахбаяр, Халамжийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Билэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Ч.БОЛД  
П.АРИУНЗАЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага туйруу-3, Засагийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ATA9693 9006109

Z:\Alban Shaardlaga\2023\0324 SNAG-4.Docx





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ 721/4014/1123

Улаанбаатар хот

СНАГ-2023/14/114-СГА-37С

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Ахмад настанд амралт, сувиллын үйлчилгээ үзүүлэх байгууллага сонгон шалгаруулах" тендерийг ахмад настан гэрээ байгуулсан амралт, сувиллын газраас өөрөө сонгон үйлчлүүлдэг учир ахмад настны тоо, мөнгөн дүнг гэрээнд тусгах боломжгүй гэх шалтгаанаар худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 255 дугаар "Журам батлах тухай" тушаалын хавсралтаар батлагдсан "Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1 "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг энэ журмын дагуу зохион байгуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулах, ил тод нээлттэй болгох, дээрх зөрчлийг арилгах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бадрахбаяр, Халамжийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Билэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

*М.Мунзаяа*

Ц.НАРАНЧИМЭГ  
Ч.БОЛД  
П.АРИУНЗАЯА

ATA9693 9006109

9023030583

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban.Shaardlaga\2023\0324 SNAG-4.Docx





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ 722/Н014/2023

Улаанбаатар хот

СНАГ-2023/14/114-СТА-ЭТГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/43 дугаар тушаалаар ахмад настанд амралтын үйлчилгээ үзүүлэх 26, сувиллын үйлчилгээ үзүүлэх 32 газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, гүйцэтгэлээр ахмад настны амралт, сувиллын үйлчилгээний зардалд 7,348,255,000.0 /долоон тэрбум гурван зуун дөчин найман сая хоёр зуун тавин таван мянга/ шилжүүлсэн боловч жилийн эцэст гэрээг дүгнээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "... ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 "гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг", Хамтрах ажиллах гэрээний 2 дугаар зүйлийн 2.20 "Тухайн жилийн гэрээний хэрэгжилтийн тайланг энэхүү гэрээний хавсралтын дагуу гарган 2022 оны 12 дугаар сарын 15-ны дотор агентлагт бичгээр хүргүүлэн гэрээг дүгнүүлнэ" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хамтран ажиллах гэрээнд заасан хугацаанд гэрээг дүгнэж байх, дотоод хяналтыг сайжруулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бадрахбаяр, Халамжийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Билэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРТҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Ч.БОЛД  
П.АРИУНЗАЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага туйруу 3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

АБЭТ-ТОЙРУУ 3  
9023030583

Z:\Alban Shaardlaga\2023\0324 SNAG-4.Docx